

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025.05.26

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.							
Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.							
1.1.1	БГТ 1.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	5 удаагийн зөвлөгөө өгөх сургалт арга хэмжээ зохион байгуулсан	Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын 2024 онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр гүйцэтгэсэн тусламж үйлчилгээнд дүн шинжилгээ хийж, 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн дээр Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс дараах чиглэлээр мэдээлэл хийсэн. Үүнд: - 2024 онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр гүйцэтгэсэн тусламж үйлчилгээний үзүүлэлт, цаашид анхаарах асуудал - Хөнгөлөлттэй эмийн жор бичихэд гаргаж байгаа алдаа, анхаарах асуудал - Зөрчлөөс урьдчилан сэргийлэх - Харьяа нутаг дэвсгэрийн малчдыг эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх - Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үзүүлж буй тусламж үйлчилгээ болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар иргэдэд хүргэх мэдээллийн	100

						<p>хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл өгч, санал хүсэлтийг сонсож, хариулт өглөө.</p> <p>Гэрээт эмийн сангуудын эрхлэгч нарт 2025 оны 1 дүгээр сарын 21-ны өдөр сургалт хийж, 2024 онд даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн үйлчилгээний үзүүлэлт, цаашид анхаарах асуудал, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээ үзүүлэхэд эмийн сангуудын эрх, үүргийн талаар мэдээлэл өгч, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмж өгсөн.</p> <p>Сумын эрүүл мэндийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд дүн шинжилгээ хийж, архаг өвчний хяналтыг сайжруулах, багийн эмч нарын үйл ажиллагааг сайжруулах, зайлшгүй хэвтүүлэн эмчлэх шаардлагатай иргэдийг хэвтүүлэн эмчилж, хуваарилагдсан төсвийг бүтэн жилийн хугацаанд жигд хуваарилан тусламж үйлчилгээний тасалдалгүй байдлыг ханган ажиллах зөвлөмжийг 2025 оны 07/40 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p>	
1.1.2	<p><i>БГТ 1.2.4</i> Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.</p>	-	Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо	-	Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан байна.	Хугацаа болоогүй. Статистик мэдээллийн эмхэтгэл гарахаар эрүүл мэндийн байгууллага, иргэдэд түгээн сурталчлахаар хүлээгдэж байна.	-
1.1.3	<p>"Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.</p>	-	Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ-ийн 2024 оны 05, 06, 14 дүгээр тогтоолуудыг мөрдөж байна.	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-уудад танилцуулж, хяналт тавин ажилласан байна	Бодлого төлөвлөлтийн газраас зохион байгуулсан "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 4 дүгээр тогтоолын сургалтад аймгийн Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг бүрэн хамруулж, тогтоолын талаар мэдлэгийг дээшлүүлсэн. Тогтоолуудыг бүх гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, эмч мэргэжилтнүүддээ танилцуулж, тусламж	90

						<p>үйлчилгээндээ хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдсэн.</p> <p>Шинэчлэгдсэн тогтоолыг олон нийтэд сурталчлах зорилгоор Олон нийттэй харилцах хэлтсээс бэлтгэн ЭМДЕГ-ын фэйсбүүкийн пэйж хуудсанд оруулсан мэдээллийг тухай бүр нь Архангай аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн фэйсбүүк группд байршуулж, иргэдэд мэдээлэл түгээсэн. /хэлтсийн пэйж хуудас хаагдсан тул фэйсбүүк группт мэдээлэл оруулж байна/</p> <p>Тогтоолын өөрчлөлтийн талаар бүх эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтнуудын зөвлөгөөн дээр мэдээлэл хийсэн.</p> <p>Тогтоолын хэрэгжилтэд сар бүр хяналт хийж, эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай зөвлөмж, анхааруулгыг утсаар, цахимаар, албан бичгээр өгч ажиллаж байна.</p>	
1.1.4	<p>ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.</p>	-	<p>Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо</p>	<p>ЭМДҮЗ 2024 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж байна. Гэрээ бүхий 22 АШЭМБ-д хүргэн ажиллаа.</p>	<p>Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-уудад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.</p>	<p>ЭМДҮЗ-ийн "Төлбөрийн хэмжээ, арга хэмжээ, журам шинэчлэн батлах тухай" 3 дугаар тогтоолын талаар Бодлого төлөвлөлтийн газраас зохион байгуулсан сургалтад бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг бүрэн хамруулж, тогтоолын шинэчлэлийн талаар мэдлэгийг дээшлүүлсэн.</p> <p>Тогтоолыг бүх гэрээт 22 АШЭМБ-д хүргүүлж, эмч мэргэжилтнүүддээ танилцуулж, тусламж үйлчилгээндээ хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдсэн.</p> <p>Тогтоолын өөрчлөлтийн талаар эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтнуудын зөвлөгөөн дээр бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт мэдээлэл хийсэн.</p> <p>Тогтоолын хэрэгжилтэд сар бүр хяналт хийж, эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай зөвлөмж, анхааруулгыг</p>	100

						утсаар, цахимаар, албан бичгээр өгч ажиллаж байна.	
1.1.5	Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.	-	- Санхүүжүүлэн эн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо	ЭМДҮЗ-ийн 2023 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж байна. 2024 онд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 23464 хүн хамрагдаж, 553,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.	2025 оны эхний 4 сарын байдлаар аймгийн Нэгдсэн эмнэлэг нийт 580 хүнд эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийж, нэхэмжилснийг хянаж, 103,171,000 төгрөгний санхүүжилт олгохоор баталгаажуулж, Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн. Ар Тооромт хувийн хэвшлийн эмнэлэг эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийх гэрээ байгуулж, нийт 1221 хүнд эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийж нэхэмжилснийг хянаж, 216,440,000 төгрөгний санхүүжилт олгохоор баталгаажуулж, Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн. Тана Арцат хувийн хэвшлийн эмнэлэг эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийх гэрээ байгуулж, нийт 473 хүнд эрт илрүүлэх оношилгоо шинжилгээ хийж нэхэмжилснийг хянаж, 84,960,000 төгрөгний санхүүжилт олгохоор баталгаажуулж, Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.	100
1.1.6	ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.	-	Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо	АШЭМБ-уудын сэргээн засах тусламж үйлчилгээнд дүн шинжилгээ хийж, БТГ-т санал хүргүүлсэн	Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	Сумын эрүүл мэндийн төвүүдийн эхний хагас жилд үзүүлсэн түргэн тусламжийн үйлчилгээ, яаралтай тусламж үйлчилгээ, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд эхний хагас жилийн гүйцэтгэл дууссаны дараа буюу 6 дугаар сарын 10-30-ны хооронд дүн шинжилгээ хийж, бодлогын арга хэмжээний санал боловсруулж хүргүүлэхээр төлөвлөсөн.	-
1.1.7	“ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.		Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо -Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо	ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг мөрдөж байна.	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна.	Тогтоол шинэчлэгдэн батлагдаагүй, хүлээгдэж байна.	-

1.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд:							
1.2.1	Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.1.3, БГТ-1.4.3 Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.	-	Хүргүүлсэн саналын тоо	3 тогтоол, 3 журмын төсөлд нийт 48 саналыг хүргүүлсэн.	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	Дараах журмын төсөлд санал хүргүүлсэн. Үүнд: - 2025 оны 12/02 дугаартай дотоод бичгээр Бодлого төлөвлөлтийн газарт эрүүл мэндийн даатгалын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр 8 санал, - 12/05 дугаартай дотоод бичгээр Бодлого төлөвлөлтийн газарт "Эрүүл мэндийн даатгалын орлого бүрдүүлэлтийн журмын төсөлд" 3 санал	50
1.2.2	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.	-	Зөрчлийн хэргийн тоо -Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн	Анхан шатны шүүхэд 48 иргэнтэй холбоотой 89,048,899 төгрөгний нэхэмжлэл гаргаж, 56,390,251 төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд буцаан төлүүлсэн.	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	Прокурорын байгууллага Цагдаагийн газартай хамтран ажиллаж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12.1.1-д заасны дагуу гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг буруутай этгээдээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад нөхөн төлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Цагдаагийн газарт гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирч, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж авсан 41 иргэний лавлагааг гаргаж өгсөн. Прокурорын газарт 2023-2024 онд гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирч, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж авсан 33 иргэний мэдээллийг нөхөн гаргаж өгсөн. Цагдаагийн газарт нэхэмжлэгчийн мэдүүлэг 41 удаа өгсөн. Архангай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 24 иргэнтэй холбоотой 42,009,533 төгрөгний нэхэмжлэл гаргаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар холбогдогч иргэдийн төлбөрийн чадвартай уялдуулан төлөлт хийх хуваарь гарган гэрээ байгуулж, иргэд хуваарийн дагуу эхний 5 сарын байдлаар 25,865,000 төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд буцаан төлөөд	100

						байна. Үлдсэн төлбөрийг хуваарийн дагуу төлөгдөхөөр хүлээгдэж байна.	
2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.							
2.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т заасан “Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд:							
2.1.1	ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 онд 36 %	2025 онд 40 хувиас дээш хамруулна.	Малчдыг эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07/13 тоот албан бичгээр аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулах 2025 оны гэрээнд өөрөө шимтгэлээ хариуцан төлдөг малчдыг эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх заалтыг оруулах тухай албан бичгийг хүргүүлж, гэрээнд тусгуулсан. Эхний 4 сарын байдлаар сум бүрийн малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын тоо болон даатгалд хамрагдалтыг эрчимжүүлэх тухай албан бичгийг сумын Засаг дарга нарт 07/134 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Бодлого төлөвлөлтийн газраас өгсөн мэдээгээр 2025 оны эхний 4 сарын байдлаар малчдын шимтгэл төлөлт 71 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
		-	Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 онд 71 %	2025 онд 80-аас дээш хувь хамруулна	Оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07/13 тоот албан бичгээр аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн захирал нартай байгуулах 2025 оны гэрээнд оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх заалтыг оруулах тухай албан бичгийг хүргүүлж, гэрээнд тусгуулсан. Аймгийн Багшийн сургууль, коллеж, МСҮТ-ийн захирлуудад оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд болон 18-30 насны эрт илрүүлэг	100

						үзлэгийн багцад бүрэн хамруулах тухай 07/133 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Бодлого төлөвлөлтийн газраас өгсөн мэдээгээр 2025 оны эхний 4 сарын байдлаар оюутны шимтгэл төлөлт 91 хувийн гүйцэтгэлтэй байна.	
			Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь	2024 онд 76 хувь	2025 онд 78-аас дээш хувь хамруулна.	Аймгийн төвийн нийтийн худалдааны төвүүдээр явж, 50 гаруй иргэнд эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, шимтгэл төлөлтийн хэмжээ, и-баримт, и-монголиа аппликейшнээр шимтгэлээ хялбар төлөх арга зэрэг зөвлөгөө, мэдээллийг өгсөн. Бодлого төлөвлөлтийн газраас өгсөн мэдээгээр 2025 оны эхний 4 сарын байдлаар хувиараа хөдөлмөр эрхлэгч болон тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн шимтгэл төлөлт 52 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
		-	Байгууллага, аж ахуйн нэгжийн хувь	2024 онд 103%	2025 онд шимтгэл төлөлт 100 хувиас доошгүй байна.	Аймгийн Нийгмийн даатгалын газрын эхний 1 дугаар улирлын тайлангаар нийт 769 байгууллага, аж ахуйн нэгжийн 10213 ажилтан эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлж, хамрагдалт 100 хувьтай байна.	100
2.1.2	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.	-	Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, тайлан мэдээг нэгтгэн 4 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган 4 удаа хүргүүлсэн байна.	Сангийн зарлагын 2024 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн, гэрээт 65 байгууллагатай тооцоо нийлсэн актын хамт Санхүү бүртгэлийн хэлтэст 2025 оны 1 дүгээр сарын 15-нд хугацаанд нь хүргүүлсэн. 2025 оны эхний 1 дүгээр улирлын сангийн зарлагын тайланг 5 сарын 15-ны өдөр Санхүү бүртгэлийн хэлтэст хугацаанд нь бүрэн, зөв гаргаж хүргүүлсэн. Нийт давхардсан тоогоор 92194 иргэнд үзүүлсэн тусламж үйлчилгээнд 8,502,678,088 төгрөгний санхүүжилтийг ЭМДСангаас олгохоор Санхүү бүртгэлийн хэлтэст нэхэмжлэл, баталгаажуулах хуудсыг хүргүүлсэн. Үүнд: Анхан шатны 22 байгууллага нийт 18643 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлж,	100

						1,787,515,574 мян/төгрөгний санхүүжилт, Нэгдсэн эмнэлэг нийт 38746 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлж, 4,911,033,722 мян/төгрөгний санхүүжилт, хувийн хэвшлийн 4 эмнэлэг нийт 2411 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлж, 412,384,133 мян/төгрөгний санхүүжилт, 1 сувилалд 365 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлж, 165,998,889 мян/төгрөгийн санхүүжилт, 37 эмийн сан 30278 иргэнд хөнгөлөлттэй эмээр үйлчилж, 913,184,770 мян/төгрөгний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон.	
2.1.3	ЭМДТХ-9.1.9 "Алсын хараа 2050", МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7 Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж тайлагнана.	-	Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2024 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна	Ажил олгогч болон даатгуулагчийн төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого эхний 4 сарын байдлаар 2,250,000,000 төгрөг төлөвлөгдсөнөөс 2,493,569,820 төгрөг төлөгдөж, 111 хувьтай биелсэн.	100
2.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т заасан "Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална" зорилтын хүрээнд:							
2.2.1	Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.2.1, БГТ-2.2.1 Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.	-	-Өглөг, авлагын тоо хэмжээ -Тайлан	2024 онд 61 ЭМБ-д 2,2 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан тайланг гаргаж, ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна.	2025 оны эхний 4 сарын байдлаар шинээр авлага үүсээгүй. 2024 онд 65 эрүүл мэндийн байгууллагад ЭМДЕГ-аас өгөх 4,068,489,024 төгрөгийн өглөгийг барагдуулсан. 2025 оны эхний 5 сарын байдлаар 4 эрүүл мэндийн байгууллагад 48,764,791 төгрөгийн өглөгтэй байна.	100
3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна							
3.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-т заасан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна" зорилтын хүрээнд:							
3.1.1	Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.1.2, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1	-	Гэрээ дүгнүүлсэн эрүүл мэндийн	2024 онд 65 гэрээт ЭМБ-ыг дүгнэсэн	Гэрээт ЭМБ-уудын гэрээг хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан	Гэрээт 65 эрүүл мэндийн байгууллагын 2024 оны гэрээг дүгнэж, гэрээний үнэлгээ, тайланг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хугацаанд нь хүргүүлсэн. Үүнд:	100

	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна		байгууллагын тоо		авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна.	Гэрээт 37 эмийн сангийн гэрээг дүгнэж, 35 эмийн сан 90 хувиас дээш, 2 эмийн сан 80-89,9 хувь үнэлэгдсэн. 90-ээс доош үнэлэгдсэн 2 эмийн санд улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. Гэрээт лавлагаа шатлалын 5 эмнэлгийн гэрээг дүгнэж, аймгийн Нэгдсэн эмнэлэг 81,6 хувь, 2 хувийн хэвшлийн эмнэлэг 90 хувиас дээш, 2 хувийн хэвшлийн эмнэлэг 80-89,9 хувь үнэлэгдсэн. Гэрээт 1 сувилал 90-ээс дээш хувь үнэлэгдсэн. Гэрээт 22 анхан шатны эрүүл мэндийн байгууллагын гэрээг дүгнэсэн. 3 өрхийн эрүүл мэндийн төв, 13 сумын ЭМТ 70-89,9 хувь, 4 сумын ЭМТ 69,9-ээс доош хувь үнэлэгдсэн. Хангалтгүй үнэлэгдсэн Цэцэрлэг, Өндөр-Улаан, Эрдэнэбулган, Эрдэнэмандал сумын эрүүл мэндийн төвүүдэд улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн.	
			Гэрээний хэрэгжилтийн хувь	2024 онд гэрээний хэрэгжилт 82 хувь	Гэрээний хэрэгжилтийн хувь 90 хувиас доошгүй байна.	Гэрээт 65 эрүүл мэндийн байгууллагын гэрээний үнэлгээний дундаж хувь 88,5 байна.	100
3.1.2	2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.		Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Өрхийн ЭМТ-3, Сумын ЭМТ-19, Лавлагаа шатлал -5, Сувилал-1, Эмийн сан-37	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.	2025 онд нийт 37 эмийн сантай "Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх" гэрээ байгуулах үйл ажиллагааг 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдөр зохион байгуулж, гэрээг баталгаажуулан Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн. 3 өрхийн ЭМТ, 19 сумын ЭМТ-тэй "Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах" гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр зохион байгуулж, гэрээг баталгаажуулан Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан үндсэн гэрээний хугацаа дуусаагүй байгаа. ЭМДҮЗ-ын 2025 оны 4 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд нэмэлт гэрээний	100

						хэлцэл хийх үйл ажиллагааг 2025 оны 3 дугаар сарын 18-19-ны өдрүүдэд зохион байгуулж, хэлцлийг хийж баталгаажуулан, эрүүл мэндийн байгууллагуудаас өгсөн төсвийн сарын хуваарийн хамт Худалдан авалт гэрээлэлтийн газарт хугацаанд нь хүргүүлж, нэмэлт гэрээг бүх лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд байгуулсан. ЭМДҮЗ-ийн 2025 оны 4 дүгээр тогтоол шинэчлэн батлагдсантай холбогдуулан сум, өрхийн ЭМТ-үүдтэй байгуулах “Нэмэлт гэрээ”-г баталгаажуулж, Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн.	
3.1.3	Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан	Лавлагаа шатлалын гэрээт 5, Сумын ЭМТ 19, өрхийн ЭМТ 3, 1 сувиллыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан.	Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	Чанар, төлбөрийн хяналтын журамд одоогоор өөрчлөлт орж батлагдаагүй байна.	-
3.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2-т заасан “Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна” зорилтын хүрээнд:							
3.2.1	БГТ-3.2.1 Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.	-	Хянасан түүврийн тоо Шалгуур хангаагүй тусламжийн тоо Хасагдсан санхүүжилтийн хэмжээ	Хянасан түүврийн тоо-12,248 Шалгуур хангаагүй тусламжийн тоо-2086 Хассан санхүүжилт - 635,239,565	Хуваарилагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хугацаанд нь журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын нийт 5133 түүвэрлэгдсэн тусламж үйлчилгээнд олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурын дагуу хугацаанд нь хяналтыг хийж, шалгуур хангаагүй 418 тусламж үйлчилгээний 154,977,337 төгрөгний хасалтыг хийсэн. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг хянаж, шалгуур хангаагүй 204 тусламж үйлчилгээний 30,664,628 төгрөгний хасалтыг хийсэн. Нэхэмжлэлийн хяналтын хасалттай холбоотой эрүүл мэндийн байгууллагуудаас	100

						санал гомдол, болон нэмэлт хяналт хийлгэх хүсэлт ирээгүй.	
3.2.2	БСТ-3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	-	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2024 онд 25 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.	<p>Бүх АШЭМБ-уудын эмч, мэргэжилтнүүдэд Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар хэрэгжүүлж буй 6 настны үзлэгийг зохион байгуулахад эрүүл мэндийн даатгалын байгууллагад гүйцэтгэлийг хэрхэн илгээж, санхүүжилтийг олгох талаар цахим сургалт зохион байгуулсан.</p> <p>ЭМДаатгалын хөнгөлөлттэй эмийн жор бичихэд анхаарах асуудлаар Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 07/118 дугаартай албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Сумын эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн гүйцэтгэлийн нэхэмжлэлийг ангилал ахиулахгүй зөв нэхэмжлэх чиглэлээр цахимаар зөвлөмж өгсөн.</p> <p>Бүх анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад 07/88, 07/98, 07/119 дугаартай албан бичгүүдээр эхний 3 сарын гүйцэтгэлийн нэхэмжлэлийн хасагдлын эргэн мэдээлэл болон тусламж үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах зөвлөмжийг тухай бүр нь хүргүүлсэн.</p> <p>Бүх сумын эрүүл мэндийн төвүүдэд 07/40 дугаартай албан бичгээр хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний төсвийн зарцуулалтын эргэн мэдээлэл, зайлшгүй шаардлагатай иргэдийг хэвтүүлэн эмчлэх тухай зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>Гэрээт бүх ЭМБ-уудад эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж үйлчилгээний гүйцэтгэл, нэхэмжлэл, санхүүжилт, программтай холбоотой үүссэн өдөр тутмын асуултуудад тухай бүр нь хариулт, зөвлөгөө, мэдээллүүдийг өөрсдөө болон ЭМДЕГ-ын холбогдох газар, хэлтсүүдээс тодруулж, эргэн мэдээлэл, зөвлөгөө өгч, ямар нэгэн гомдол санал, алдаа, дутагдал гараагүй.</p>	90

3.2.3	<p>Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч)ахлах(-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.</p>	-	<p>Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь</p>	<p>Зөвлөмж -15, албан шаардлага -1 Хэрэгжилтийн хувь - 100</p>	<p>Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.</p>	<p>Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн нэхэмжлэлийг хянаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тухай улсын байцаагчийн дараах зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2024 оны сүүлийн хагаст иргэн даатгуулагчдад үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн нэхэмжлэлд хийсэн хяналтаар шалгуур хангаагүй үйл ажиллагаануудыг сайжруулах тухай улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тана арцат, Ар тооромт, Хасу Ар, Зүүхэн эмнэлгүүдэд өгсөн. - Сумын эрүүл мэндийн төвүүдэд “Яаралтай тусламжийн чанар, үр дүнг сайжруулах, ангилал ахиулж нэхэмжлэхгүй байх” Улсын ахлах байцаагчийн зөвлөмж - Аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Сэтгэлзүйн үзлэг, зөвлөгөө”-ний тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг үнэн, зөв нэхэмжлэх тухай Улсын ахлах байцаагчийн зөвлөмж - Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний биелэлтийг 80-аас доош хувь биелүүлсэн аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хасу манал ар эмнэлэг, Ар тооромт эмнэлэг, Тана арцат эмнэлгүүдэд Гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах тухай улсын байцаагчийн зөвлөмж - Эмийн сангуудын 2024 оны “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-ний биелэлтийг 90-ээс доош хувь биелүүлсэн 	100
-------	--	---	---	--	--	---	-----

						<p>Жаргалант цээнэ, Донгойн хишиг эмийн сангуудад Улсын ахлах байцаагчийн зөвлөмж</p> <ul style="list-style-type: none"> - Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний биелэлтийг 70-аас доош хувь биелүүлсэн Өндөр-Улаан, Эрдэнэбулган, Цэцэрлэг, Эрдэнэмандал сумын ЭМТ-үүдэд Улсын ахлах байцаагчийн зөвлөмж 	
3.2.4	<p><i>Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.2.3, БГТ-3.2.2</i></p> <p>Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.</p>	-	<p>Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо -Хяналт шалгалтын тайлан</p>	<p>2024 онд гэрээт 1 байгууллагад 2 удаа газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан.</p>	<p>Газар дээрх хяналт, шалгалт хийж, тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.</p>	<p>Худалдан авалт гэрээлэлтийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Өлзийт сумын эрүүл мэндийн төвийн шүдний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг цахимаар хянаж, хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлтийг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хугацаанд нь хүргүүлсэн.</p> <p>2025 оны эхний 5 сарын байдлаар нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж үйлчилгээтэй холбоотой байгууллага, иргэнээс гомдол, санал ирээгүй.</p>	100
4.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.							
4.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т заасан “Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинэ” зорилтын хүрээнд:							
4.1.1	<p><i>ЗГҮАХ-2.1.9, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.3</i></p> <p>Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ.</p>	-	<p>-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо. -Тайлан</p>	<p>Засгийн газрын 2023 оны 272-р тогтоолын дагуу орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 20 хувиар тооцож, 2025 оны 1-р</p>	<p>Орон нутгийн удирдлагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Аймгийн Засаг даргын тамгын газраас Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн ажиллах нөхцлийг бүрдүүлж, аймгийн Засаг даргын тамгын газрын 2 дугаар байрны 3 давхарын 2 өрөөг ямар нэг түрээс, ус, цахилгааны зардалгүйгээр ашиглуулж, хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлөөр хангаж байна.</p> <p>Орон нутгаас зохион байгуулж буй бүх сургалт, семинарын мэдээллийг аймгийн ЗДТГ-аас хэлтсийн мэйл хаягаар ирүүлж, сургалт, зөвлөгөөнд тухай бүр нь оролцуулж, мэдээллээр хангаж байна.</p>	100

				сараас өгөхөөр шийдвэрлэсэн.		Орон нутгийн төсвөөс төрийн захиргааны албан хаагчдад олгох орон нутагт ажилласны 20 хувийн нэмэгдлийг хэлтсийн албан хаагчдад 2025 оны 1 дүгээр сараас эхлэн сар бүр тасралтгүй олгож байна.	
4.1.2	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо	Зохион байгуулсан арга хэмжээ-5, хамрагдсан хүний тоо - 220	Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.	2 коллеж, 1 МСҮТ-ийн нийт 100 гаруй оюутанд эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, и-баримт аппликейшн болон и-монголиа аппликейшн ашиглан ЭМДаатгалын шимтгэл төлөлтөө шалгах, шимтгэлээ төлөх талаар мэдээлэл өгсөн. Нийтийн худалдааны төвд хувиараа худалдаа эрхлэгч иргэд болон үйлчлүүлэгч нийт 50 гаруй иргэнд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, и-баримт аппликейшн, и-монголиа аппликейшн ашиглан ЭМДаатгалын шимтгэл төлөлтөө шалгах, шимтгэлээ төлөх талаар мэдээлэл өгсөн. ЭМДаатгалын шимтгэлийн хэмжээ, шимтгэлээ төлөлтийг сурталчлах зорилгоор ЭМДЕГ-ын ОНХХ-ээс ирүүлсэн сурталчилгааны материалуудыг гэрээт 65 эрүүл мэндийн байгууллагад бүрэн хүргүүлж, ил тод байршуулан, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулсан.	100
4.1.3	Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.	-	Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо	ЭМДЕГ-ын фэйсбүүкийн пэйж хуудсанд байршуулсан мэдээллийг түгээсэн хувь-90%, ЭМДХ-ээс бэлтгэсэн	ЭМДЕГ-ын фэйсбүүкийн пэйж хуудсанд байршуулсан мэдээллийг 90-ээс дээш хувь түгээнэ ЭМДХ-ээс 10-аас дээш контент бэлтгэнэ	Архангай аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс гэсэн фэйсбүүк групп хуудсыг /пэйж хуудас хаагдсан. пэйж хуудсаа буцааж нээлгэх мэйлийг фэйсбүүк рүү бичсэн./ тогтмол ажиллуулан, эрүүл мэндийн даатгалаар иргэдэд үзүүлж буй тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах үйл ажиллагааг тогтмол хийж, ЭМДЕГын фэйсбүүкийн пэйж хуудсанд байршуулсан	80

				контентын тоо – 12 Хандалтын тоо -2300		мэдээллийг тухай бүр шэйрлэн нийт 300 гаруй мэдээлэл оруулж иргэдэд хүргэсэн. Давхардсан тоогоор 1000 орчим хүн хандаж мэдээлэл авсан. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн пэйж хуудсанд хэлтсийн байршлын хаяг, мэйл хаяг, утасны дугаарыг ил байрлуулсан. Хэлтсийн үүдний хэсэгт эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт, Е-баримт аппликэйшнээр эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөө хялбар төлөх заавар, ЭМДаатгалын шимтгэл төлөлтийн хэмжээг ил байршуулсан.	
4.1.4	<i>БГТ 4.1.10</i> Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.	-	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	474 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан.	Сэтгэл ханамжийн судалгаа авч, хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	ЭМДЕГ-ын Олон нийттэй харилцах хэлтсээс зохион байгуулж байгаа байгууллагын үйл ажиллагааг үнэлэх сэтгэл ханамжийн судалгаанд гэрээт ЭМБ-уудыг оролцохыг 07/89 дугаартай албан бичгээр мэдэгдэж, нийт 150 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд судалгаанд оролцсон.	100
4.1.5	<i>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.15</i> Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.	-	Албан бичиг, санал, хүсэлт, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	Өргөдөл, гомдлын тоо 4, хүсэлт 800, шийдвэрлэлт 100 хувь.	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	ЭМДаатгалын шимтгэл илүү төлөлттэй холбоотой ирсэн 6 өргөдлийг Санхүү бүртгэлийн хэлтэст шилжүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт шалгуулах, И-монголиа, Е-баримт аппликэйшнээр шимтгэл төлөх, шимтгэлийн илүү төлөлтийг буцаах болон шинэ төрсөн хүүхдийн овог, нэр оруулах, төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн ноогдуулалт хийлгүүлэх талаар утсаар, биеэр, цахимаар хандсан 500 орчим иргэнд тухай бүр нь асуудлыг шийдвэрлэж, зөвлөгөө мэдээлэл өгч, санал гомдол гараагүй.	100

4.1.6	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллана.	-	Өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн хувь.	ЭМДЕГ-ын удирдлагын шуурхайгаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 17 удаа гаргаж, хэрэгжилт 100 хувь	Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнасан.	100
4.1.7	Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг, даалгавар болон хэлтсийн дотооддоо хийж гүйцэтгэсэн ажлуудын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнана.	-	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	-	Үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнасан.	100
4.1.8	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	-	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний	Хэлтсийн мэргэжилтэний гүйцэтгэл-ийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж, ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан	Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.	Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан хэлтсийн мэргэжилтэн Ч.Мягмарсүрэнгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж, ажлын цаг баримтлалтад хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар ханган, хэлтсийн хэрэгжүүлэх чиг үүргийн үйл ажиллагааг тухай бүрт нь хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллаж байна. Мэргэжилтэн Ч.Мягмарсүрэнгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг 5 дугаар сарын 23-ны өдөр дүгнэж, мэргэжилтэн Ч.Мягмарсүрэн 91,8 хувь үнэлэгдсэн.	100
4.1.9	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө.	-	Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо	2024 оны 36 архивын нэгжийг бүрдүүлж, албан бичиг	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байна.	Архивын улсын үзлэгтэй холбоотойгоор аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан "Баримт бичгийн стандарт, баримт бичиг зохион бүрдүүлэх аргазүй, анхаарах	100

				хөтлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.		асуудал” сургалтад оролцож, мэдлэгээ дээшлүүлсэн. Хэлтсийн албан бичиг хөтлөлтийг стандартын дагуу боловсруулж, файл хэлбэрээр болон цаасан хэлбэрээр хадгалж байна. 2024 оны 11,12 сарын баримтуудыг 15 боть, 2025 оны эхний 1-р улирлын баримтуудыг 20 боть болгон архивын нэгж үүсгэн хадгалж байна. 2024 оны баримтуудыг Аудитад шалгуулсны дараа ЭМДЕГ-ын архивт хүлээлгэн өгөхөөр хүлээгдэж байна. 2025 оны эхний 1-р улирлын албан бичгүүдийг PDF файл болгож, Тамгын газрын бичиг хэрэгт хүргүүлэхээр бэлтгэсэн.	
4.1.10	Монгол хэлний тухай хуулийн 24-р зүйлийн 7.2 дах хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1-р сарын 01-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна.		Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо, хэрэгжилтийн хувь	-	Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.	Тамгын газраас албан бичгийг монгол бичиг рүү хөрвүүлэх программаар хангагдахаар албан бичгийг хос бичгээр бичихээр хүлээгдэж байна. Албан бичгийг монгол бичгээр бичих албан бланкийн захиалга хийж, 100 ширхэг албан бичгийн нөөцийг бүрдүүлсэн. Одоогоор манай аймагт албан байгууллагууд албан бичгийг хос бичгээр бичих үйл ажиллагааг эхлээгүй байна.	100
4.1.11	Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ		Цахим гарын үсгээр албаж албан бичгийн тоо	-	Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна.	Одоогийн байдлаар цахим гарын үсгийг ашиглаж чадаагүй байна.	0
4.1.12	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана		Хэрэгжилтийн хувь	-	Хэрэгжилтийг ханган тайлагнасан байна	Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсээс зохион байгуулсан “Авлигын эсрэг хууль”-ийн талаар төрийн албан	100

						<p>хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх сургалтад хамрагдсан.</p> <p>2025 оны эхний хагас жилийн байдлаар хэлтсийн албан хаагчдын зүгээс авилгатай холбоотой ямар нэгэн алдаа дутагдал гаргаагүй ажилласан.</p> <p>Олон нийттэй харилцах хэлтсээс бэлтгэсэн Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой авилгыг мэдээлэх мэдээллийг хэлтсийн фэйсбүүк группд 2 удаа нийтэлж, иргэдэд мэдээлэл хүргэсэн.</p> <p>Хэлтсийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, хэлтсийн фэйсбүүк группд ЭМДЕГ-ын пэйж хуудсанд байршуулсан мэдээллийг тухай бүр тогтмол байршуулж, иргэдэд мэдээллийг хүргэж байна.</p> <p>Гэрээт эрүүл мэндийн байгууллагууд Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж үйлчилгээтэй холбоотой авилгыг мэдээлэх сурталчилгааны постерыг /ОНХХ-ээс 2024 онд хангасан/ ил тод байршуулж, иргэдэд мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд хамтарч ажиллаж байна.</p>	
5. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль, тогтоомжид заасан мэдлэг, чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх зорилтын хүрээнд							
5.1.	Эрүүл мэндийн даатгалын шинэчлэгдсэн тогтоол шийдвэрүүдийг тухай бүр нь судалж, танилцан бүрэн мэдлэгтэй болно.		Шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх		Сургалтад бүрэн хамрагдсан байна	Бодлого төлөвлөлтийн газраас зохион байгуулсан ЭМДҮЗ-ийн 3, 4 дүгээр тогтоолуудын цахим сургалтад хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдсан. Шинэчлэн батлагдсан тогтоолуудыг хэвлэн авч, өдөр тутмын хэрэглээнд тогтмол ашиглаж, эрүүл мэндийн байгууллагуудыг аргазүйгээр ханган ажиллаж байна.	100
5.2.	БГТ 4.1.4 ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана.		Хамрагдсан сургалтын тоо	ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтуудад бүрэн хамрагдсан	ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтад бүрэн хамрагдаж, мэдлэг, мэдээлэл авсан.	ЭМДЕГ-аас зохион байгуулсан мэдээллийн цаг болон Тамгын газар, БТГ, ХАГГ, ТҮЧТХГ-уудаас зохион байгуулсан сургалтуудад тухай бүрэн хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлсэн.	100

5.3.	Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ.		Хамрагдсан сургалтын тоо	Нийт 18 удаагийн сургалтад оролцсон	Сургалт семинарт бүрэн хамрагдсан байна.	Аймгийн ЗДТГ, аймгийн Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс, Прокурорын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Төрийн аудит, Архивын тасгаас зохион байгуулсан нийт 8 удаагийн сургалтад оролцсон. "Бүсчилсэн хөгжилд төрийн албаны манлайлал" "Хангай бүсийн 2 өдрийн зөвлөгөөнд оролцож, төрийн албан хаагчийн ёсзүй, хувь хүний хөгжлийн чиглэлээр мэдлэгээ дээшлүүлсэн.	90
5.4.	Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах		Хамрагдсан сургалтын тоо		Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилж, Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна.	Монгол бичгийн онлайн хичээлийг бие дааж судалж, мэдлэгээ дээшлүүлсэн.	70

Төлөөлөгөөг үнэлсэн:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

Төсвийн шууд захирагч

(С.ЭНХБОЛД)

..... (ОГНОО)

Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн:
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

Нэгжийн дарга

(Б.ОЮУНЦЭЦЭГ)

20250624 (ОГНОО)

Тайлагнасан:
АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Нэгжийн дарга

(Д.АЛТАНТУЯА)

.....(ОГНОО)

